

Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

1-р Хичээл

Шинэ Гэрээний Теологийг
Яагаад Судлах Ёстой вэ?

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр дахин давтагдашгүй, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашигласан цуврал хичээлүүдийг бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг бөгөөд хувь хүмүүс, бүлгээрээ, сургууль дээрээ болон цахим хэлбэрээр ашиглахаар бүтээгдсэн.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид нь теологийн мэргэжлийн сургагч багш нар, орон орны орчуулагч нар маань теологийн мэдлэгтэй зэрэг давуу талтай юм. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

1-р хичээл

Шинэ Гэрээний Теологийг Яагаад Судлах Хэрэгтэй вэ?

Гарчиг

Удиртгал	1
Онгод ба Эрх мэдэл	2
Баталгаа	2
Арван Хоёр Дагалдагч	3
Элч нар ба Эш үзүүлэгчид	4
Шинэ Гэрээний номууд	5
Тодруулга	6
Онгод	6
Эрх мэдэл	10
Үргэлжлэх зарчмууд ба Үл үргэлжлэх зарчмууд	13
Цаг үе	14
Үргэлжлэх зарчмууд	14
Үл үргэлжлэх зарчмууд	15
Соёл	17
Үргэлжлэх зарчмууд	18
Үл үргэлжлэх зарчмууд	19
Хувь хүн	20
Үргэлжлэх зарчмууд	21
Үл үргэлжлэх зарчмууд	22
Дүгнэлт	24
Хамтрагчид	25
Үгсийн Тайлбар	26

Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ

1-р хичээл

Шинэ Гэрээний Теологийг Яагаад Судлах Хэрэгтэй вэ?

ТАНИЛЦУУЛГА

Та уран зураг, уран зохиол, жүжиг эсвэл кино зохиолыг мэргэжил болгон суралцаж байсан бол тэдгээрийг зүгээр л үзэж таашаах болон анхааралтайгаар дүн шинжилгээ хийх хоёр их ялгаатай гэдгийг мэдэх нь лавтай. Нарийвчилсан дүн шинжилгээ хийх нь нөр их ажил бөгөөд бид хүссэн үедээ, тааваараа оролдож үзэхээс тун өөр юм. Гэвч эцсийн эцэст та бид хоёр аливаа нэг ухаан эсвэл ур чадварыг зүтгэн судалсны үр дүнд ирэх тэр мэдлэгийг орлож чадах зүйл үгүй гэдгийг мэднэ шүү дээ.

Олон талаар Христийн дагалдагч нар Шинэ Гэрээг судлах үед яг ийм зүйл тохиолддог гэж хэлж болно. Шинэ Гэрээг байгаа газар бүрдээ, хүссэн цагтаа унших бид дуртай байдаг. Харин Шинэ Гэрээ ба Шинэ Гэрээний теологийг анхааралтайгаар судлахаас ирэх ухаарал ойлголт нь агуу амжилтын эх үндэс билээ.

Энэ бол *Шинэ Гэрээн дэх Хаанчлал ба Гэрээ* нэртэй цуврал хичээлийн эхний хичээл. Энэхүү цуврал хичээлээр бид теологийн уламжлалт тодорхойлолт тайлбарыг дагах бөгөөд Шинэ Гэрээнд Бурхан Өөрийнхөө тухай болон Түүнтэй холбоотой бусад сэдвийг хэрхэн заасан тухай Шинэ Гэрээний теологийг тайлбарлах болно. Эхний хичээлийг “Шинэ Гэрээний теологийг яагаад судлах хэрэгтэй вэ?” гэж нэрлэсэн. Энэ хичээлээр бид Шинэ Гэрээг өнгөцхөн ойлгоод өнгөрөх биш харин Шинэ Гэрээний теологийг гүн гүнзгий, анхааралтайгаар судлахад өөрсдийгөө зориулах яагаад чухал вэ гэдгийг үзэх болно.

2 Тимот 2:15-р эшлэлд, элч Паул Шинэ Гэрээний теологийг ойлгох нь амар биш гэдгийг тодорхой хэлсэн байдаг. Паул Тимотод хандан юу гэж хэлснийг харвал:

Ичих зүйлгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд өөрийгөө сайшаалган харуулахыг хичээ гэжээ.

Мэдээж Шинэ Гэрээний теологи зарим талаар тун энгийн. Гэвч Паул Бичвэрийг ойлгох нь үргэлж амар байдаггүйг энд тун тодорхой хэлсэн юм. Тимотыг энд “үнэний үгийг зөв заадаг ... ажилчин” гэж хэлсэн байна. “Ажилчин” гэдэг үгийг Грек хэлэнд “*ergates*” гэдэг ба энэ нь ихэвчлэн биеийн хүчний ажлыг хэлдэг. Паулын энэхүү зүйрлэл нь Шинэ Гэрээний теологийг ойлгоход маш их хүч хөдөлмөр хэрэгтэй гэдгийг харуулж буй юм. Шинэ Гэрээний теологийг судлах нь тийм хэцүү юм бол бид яагаад заавал судлах ёстой гэж?

Тимотод бичсэн захидалдаа Паул ердөө хэдхэн үгийн зайтай, хоёр утга санааг гаргасан нь их сонирхолтой байдаг. Эхлээд Бурхан Бичвэрийг өгсөн ба үг бол “Бурханы амьсгалснаар” байгаа гэж хэлчхээд, хэдхэн өгүүлбэрийн дараа Тимотод хандан сур, Бурханы

ажилчин гэдгээ харуулахын тулд шаргуу хичээ, Бичвэрүүдийг судалж, зөв заа гэж хэлсэн байдаг. Бурхан өгөөмөр санаачлаг гарган бидэнтэй тогтоосон тэр гэрээний харилцааг болон Түүний Үгэнд хэрхэн хандах ёстойг сайтар тусгаж өгсөн байдаг. Бидний ойлгох хэлээр Тэрээр бидэнд үгээ өгсөн. Тухайн цаг үеийнхээ газар орон болон хүмүүст хамаатай хэв маяг, хэл болон хэлбэрийг ашиглан хүмүүсээр дамжуулан Тэр ярьсан бөгөөд бид тэр хэлийг нь сурч, хэв маягийг нь ойлгож, Бичвэрт ашигласан олон хэлбэр буюу түүхэн хүүрнэл, яруу найраг болон зааварчилгаа бүхий захидлын зорилгыг ухаарах хэрэгтэй болно гэсэн үг. Библийг хам сэдэвтэй нь уялдуулан уншихдаа Шинэ Гэрээг бичсэн хүмүүс Хуучин Гэрээг хэрхэн олон янзаар ашигласныг ойлгоно гэсэн үг юм. Тухайн цаг үед эртний Бичвэрүүдийг онцгой тохиолдолд л ашиглах нь түгээмэл байсан. Тиймээс Паул Тимотод Бичвэрүүд Ариун Сүнсний хүчээр Бурханаас өгсөн зүйл юм гэж хэлснийхээ дараа Тимотыг бид ч бас Тимоттой адил хичээл зүтгэл гаргаж Бичвэрүүдийг зөв зааж байгаа гэдгээ батлан харуулахын тулд суралцах ёстой гэсэн юм.

— Др. Грег Пэрри
Ковенант Теологийн Их Сургууль

Шинэ Гэрээний теологийг яагаад ойлгох ёстой гэдгийг бид хоёр арга замаар судлах болно. Эхлээд бид Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийн ач холбогдлыг судална. Дараа нь Шинэ Гэрээний цаг үеэс өнөө үеийн үргэлжлэх болон үл үргэлжлэх зарчмуудын тухай авч үзнэ. Тэгэхээр одоо Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийг эхлээд ярилцаж дараа нь дээр дурдсан хоёр асуудлын тухай сайтар судалцгаая.

ОНГОД БА ЭРХ МЭДЭЛ

Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийг судлан үзэхийн тулд бид Шинэ Гэрээ бол Бурханы онгодоор бичигдсэн ба эрх мэдэлтэй гэдэг Библийн баталгаанд анхаарлаа хандуулах болно. Мөн бид “онгод” болон “эрх мэдэл” гэдэг нь ямар утгатай болохыг хэд хэдэн янзаар тодруулан тайлбарлана. Тэгвэл эхлээд Христийн итгэл үнэмшлийн эдгээр чухал ойлголтуудыг библи хэрхэн баталдаг болохыг авч үзье.

БАТАЛГАА

Христийн дагалдагч нар Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийн тухай ярихдаа үргэлж 2 Тимот 3:16-р эшлэл дэх Паулын үгийг эш татдаг гэж хэлж болно:

Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай (2 Тимот 3:16).

Паул “Бичвэр бүр Бурханы амьсгалснаар” байгаа гэж хэлэхдээ Бичвэрүүд нь Бурханы онгодоор бичигдсэн тухай хөндсөнийг бид харж байна. Мөн “*теопнеустос*” хэмээх Грек үгийг “Бурхан амьсгалаа гаргах” гэж орчуулж болно. Тэрээр мөн Бичвэр нь “заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай” хэмээн хэлэхдээ Бичвэрийн эрх мэдлийг тодорхойлсон юм. Христийн дагалдагч нар Шинэ Гэрээний тухайд юунд нь итгэх ёстойгоо ойлгоход энэ эшлэл тун чухал. Тэгвэл одоо 2 Тимот 3:15-р эшлэлд Паул юу гэж хэлснийг харцгаая:

Христ Есүс дэх итгэлээр авралд чамайг мэргэн болгох чадалтай ариун судар бичгүүдийг чи хүүхэд байхаасаа мэдсэн (2 Тимот 3:15).

Паул энд Тимотын “хүүхэд байхаасаа” судалсан тэдгээр “Ариун судар бичгүүд” гэж шууд утгаар хэлэхдээ Шинэ Гэрээний тухай биш харин мэдээж Хуучин Гэрээний тухай ярьж байсан нь ойлгомжтой. Тэгвэл Христэд итгэгчид Шинэ Гэрээг Бурханы онгодоор бичигдсэн бас эрх мэдэлтэй гэж тодорхойлоходоо Паулын Хуучин Гэрээний тухай энэ үгийг яагаад эш татдаг юм бол?

Шинэ Гэрээний Бурханаар бичигдсэн болон эрх мэдэлтэй байдлыг ойлгоход туслах библийн гурван баталгааг бүгдээрээ авч үзье. Эхлээд бид Есүс арван хоёр дагалдагчаа дуудсан тухай судална. Дараа нь элч нар болон эш үзүүлэгчдийн үндсэн үүргийн тухай үзнэ. Харин сүүлд нь Шинэ Гэрээний номуудын онгод болон эрх мэдлийн баталгааг судлах болно. Тэгвэл одоо Есүс арван хоёр дагалдагчаа дуудсан нь хэрхэн Шинэ Гэрээний онгод болон эрх мэдлийн баталгаа болдог болохыг харцгаая.

Арван хоёр дагалдагч

Израилд Бурханы зорилгыг биелүүлэх Бурханы хүмүүсийн шинэ эрин үеийн суурийг тавихын тулд Есүс арван хоёр дагалдагчаас бүрдсэн онцгой бүлэг хүмүүсийг дуудсан юм. Есүс энэ арван хоёр дагалдагчдыг бусад дагалдагч нараасаа тусад нь авч үздэг байсан нь Сайнмэдээний номуудад тодорхой байдаг. Энэ арван хоёрт багтсан Иудасаас бусад бүх элч нарын энэ онцгой байдал нь хожим Есүс Өөрийн эрх мэдэл бүхий элч нар болгон энэ дэлхийд илгээхэд хүргэсэн аж.

Иохан 16:13-р эшлэлд Есүсийн дагалдагч нартаа дараах үгсийг хэлсэн юм:

Харин үнэний Сүнс ирэхдээ та нарыг бүхий л үнэн өөд удирдана. Тэр Өөрөөсөө биш харин алив сонсох юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ (Иохан 16:13).

Есүсийн дагалдагч нарт сурч мэдэх зүйл их байсныг энэ эшлэлд тодорхой хэлжээ. Тиймээс “үнэний Сүнс” тэдэн дээр ирж “ирэх зүйлсийн” тухай “үнэн өөд тэднийг удирдана” гэж бичжээ. Есүс бусад дагалдагч нарт нь Ариун Сүнсний тусламжтайгаар зааж сургах үүргийг эдгээр сонгосон дагалдагч нартаа өгснийг бид эндээс харж байна. Энэ болон үүнтэй төстэй эшлэлүүд Шинэ Гэрээ Бурханы онгодоор бичигдсэн гэдэгт итгэх итгэлийг баталгаажуулдаг билээ.

Шинэ Гэрээний ихэнх хэсгийг бичсэн элч Паул анхны арван хоёрын нэг байгаагүй ч эрх мэдэлтэй элч байсан бөгөөд тэрээр арван хоёрт зориулан тогтоосон шаардлагад бүрэн нийцэж байсныг Үйлс 1:21-22-р эшлэлээс харж болно. Паул Дамаск руу явах замдаа Христтэй учирсан тухай Лук гурван ч удаа бичсэн нэг шалтгаан нь энэ юм. Эхнийх нь Үйлс 9:1-19, дараагийнх нь 22:6-11, сүүлийнх нь 26:9-18. Мөн Галат 1:11–2:10-р эшлэлд Паул Арабын элсэн цөлд Христтэй хамт гурван жилийг өнгөрүүлсэн тухай өгүүлсэн нь ч бий. Мөн энэ эшлэлд Иерусалимд байсан элч нар Паулын элчийн эрх мэдлийг нь баталгаажуулсан байдаг. Есүс 500 гаруй итгэгчдэд харагдсан тухай хэлснийхээ дараа Паул мөн 1 Коринт 15:8-9-р эшлэлд ийнхүү хэлсэн:

Бүгдийн эцэст дутуу төрсөн мэт надад ч Тэр [Есүс] бас үзэгдсэн билээ. Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм (1 Коринт 15:8-9).

Элч байсан хэр нь Паул өөрийгөө “дутуу төрсөн мэт” ба “элч нараас хамгийн өчүүхэн нь” гэж хэлсэн байдаг. Эрх мэдэл бүхий төлөөлөгч нарын дундаас тэр л ганцаараа Есүсийн газар дэлхий дээрх үйлчлэлийн үеэр хамт байгаагүй элч юм. Гэвч Паул бол Есүс үхлээс амилсныг харсан гэрч бөгөөд Иерусалимд байсан анхны элч нар ч үүнийг нь баталсан байдаг.

Есүс Өөрийн арван хоёр дагалдагчдыг дуудсантай холбоотой баталгааг бид ойлгохын хамт мөн 1-р зууны элч нар болон эш үзүүлэгчид Ариун Сүнсээр хөтлөгдөж байсан ба эрх мэдэлтэй байсныг дурдах нь зүйтэй.

Элч нар болон эш үзүүлэгчид

Ефес 3:4-5-р эшлэлд Паул зөвхөн тэр өөрөө биш харин Христийн элч нар болон эш үзүүлэгчид Бурханы онцгой илчлэлийг хүлээн авсан хүмүүс гэдгийг хэрхэн тодорхойлж хэлснийг анхааралтай тунгаан бодоорой:

Христийн нууцын талаарх ойлголтыг минь мэдэж чадна ... Сүнс дор Түүний ариун элч нар ба эш үзүүлэгчдэд илчлэгдсэнээр... (Ефес 3:4-5).

Энд Паул Христитгэлийн сургаал номлолууд “Сүнс дор ариун элч нар болон эш үзүүлэгчдэд илчлэгдэх” хүртлээ нууцлагдаж байсан эсвэл “тайлагдашгүй” байсныг онцгойлон дурдсан байна. Энд гайхах зүйлгүй бөгөөд Ефес 2:20-21-р

эшлэлд Паул анхны элч нар болон эш үзүүлэгчдийн тухай мөн доорх маягаар тайлбарласан байдаг:

[Сүм чуулган] элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ. Түүний дотор бүх барилга холбогдон Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна (Ефес 2:20-21).

Энэ эшлэл бидэнд Бурхан сүм чуулганыг “Эзэн доторх ариун сүм болгохоор” барьж байгуулж байгаа бөгөөд Есүс Христ бол “булангийн чулуу” гэж хэлжээ. Гэхдээ энд Паул мөн “элч нар болон эш үзүүлэгчид” ч бас сүм чуулганы суурийн нэгэн хэсэг гэж тодорхойлсон байгааг анзаарч байна уу. Өөрөөр хэлбэл Бурхан сүм чуулганыг элч нар болон эш үзүүлэгчдийн эрх мэдэлтэй сургаалын суурин дээр барьж байгуулсан гэдгийг харуулж буй юм. Өмнөх эшлэлээс харсанчлан элч нарын болон эш үзүүлэгчийн сургаал номлол нь Ариун Сүнсээр хийгддэг тул эрх мэдэлтэй юм.

Есүсийн арван хоёр дагалдагчид, Христийн элч нар болон эш үзүүлэгчдийн суурь болсон эрх мэдлийн талаарх Библийн баталгааг ойлгохын сацуу Христийн элч нар болон эш үзүүлэгчид Шинэ Гэрээг Хуучин Гэрээний Бичвэрүүдтэй эн тэнцүү гэж үзэж байсныг орхигдуулж болохгүй. Энэ санаа Шинэ Гэрээнд олон удаа дурдагдсан байдаг ч бид одоо ердөө хоёр жишээг л авч үзье.

Шинэ Гэрээний номууд

Юуны өмнө 1 Тимот 5:18-р эшлэлд Паул ингэж бичсэн:

Учир нь Бичвэр “Тариа цайруулж байгаа үхэрт хошуувч бүү хий”, “Ажилчин хөлсөө авах нь зохистой” гэж хэлдэг (1 Тимот 5:18).

Энэ эшлэлийг анх уншихад ойлгомжгүй санагдаж болох ч Паул “Бичвэр хэлсэн” гэдэг үгээр эхэлсэн нь бидний анхаарлыг татна. Тэгээд Паул хоёр өөр эшлэлийг араас нь хэлсэн. Эхний хэлсэн өгүүлбэр буюу “Тариа цайруулж буй үхэрт хошуувч бүү хий” гэдэг эшлэлээ тэрээр Хуучин Гэрээний Дэд Хууль номоос авсан. Харин хоёр дахь өгүүлбэрээ Шинэ Гэрээний Лук номын 10:7-р эшлэлээс авсан. Хуучин болон Шинэ Гэрээг ийнхүү холбосон нь элч Паул Христийн элч нар болон эш үзүүлэгчдийн бичсэн номуудыг Хуучин Гэрээний Бичвэрүүдтэй адил тэнцүү гэж үзсэн нь харагдаж байна.

Мөн 2 Петр 3:15-16-р эшлэл дээр элч Петр төстэй зүйл бичсэнийг харж болно:

Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн ... Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж ... (2 Петр 3:15-16).

Петр энэ эшлэлд Паулыг “Бурханы өгсөн мэргэн ухаанаар” бичсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл Паулын бичсэн номууд Бурханы эрх мэдлийг тээдэг гэсэн үг юм. Мөн Петр энд Христитгэлийг эсэргүүцэгчид “Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ” Паулын захидлуудыг ч гуйвуулсан явдлыг онцолсныг анхаараарай. Нухацтай бодож үзвэл Петр “бусад Бичвэр” гэдэг үгээрээ Хуучин Гэрээний Бичвэрүүдийн тухай хэлсэн нь ойлгомжтой. Тэгэхээр бид эндээс элч Петр Шинэ Гэрээний номуудыг Хуучин Гэрээтэй адил Бурханы онгодоор бичигдсэн ба эрх мэдэлтэй гэж үзэж байсныг тодорхой харж болно.

Шинэ Гэрээ бол Бурханы сүм чуулгандаа хандан хэлж буй Бурханы онгод ба эрх мэдэлтэй үг гэдгийг Библи баталдаг. Элч нарыг нь Сүнс замчлан чиглүүлнэ гэж Есүс Өөрөө амласан юм. Тэр элч нар болон эш үзүүлэгчдээ сүм чуулганыхаа тулганы чулуу буюу суурийг тавих эрх мэдэлтэй хүмүүс болгосон юм. Үүнээс гадна Бурханы хүмүүс Хуучин Гэрээг Бурханаас эхтэй ба эрх мэдэлтэй үг гэж хүлээж авсны адилаар Христийн элч нар болон эш үзүүлэгчдийн бичсэн зүйлсийг ч мөн Бурханы онгодоор бичигдсэн ба эрх мэдэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь сүм чуулганы дуудлага юм.

Шинэ Гэрээний онгод ба эрх мэдэлд итгэх итгэлийг маань батлах олон баталгааг Библиэс харсан болохоор одоо бид энэ хоёр нэр томьёог Тодруулан тайлбарлах нь зүйн хэрэг.

ТОДРУУЛГА

Христитгэгчид “онгод” ба “эрх мэдэл” хэмээх эдгээр үгсийг Шинэ Гэрээтэй холбохдоо утгыг нь ихэнхдээ буруу ойлгосон байдаг. Энэ хоёр ойлголтыг үнэн гэж батлах нь чухал байдагтай адил бид утгыг нь зөв ойлгох нь бас чухал.

Шинэ Гэрээний энэ хоёр шинж чанарыг тус тусад нь тайлбарлаж тодруулъя. Эхлээд бид Шинэ Гэрээний онгод гэдэг нь ямар утга учиртайг тодруулна. Дараа нь Шинэ Гэрээний эрх мэдэл гэсэн үгийг тодруулах болно. Иймээс одоо Шинэ Гэрээний онгод гэдэг үгийг авч үзье.

Онгод


Шинэ Гэрээ Бурханы онгодоор бичигдсэн эсвэл Бурханы “амьсгалснаар” гэдэг үгийн тухай түүхийн туршид Христийн дагалдагч нар өөр өөр ойлголттой байсаар ирсэн. Эдгээр ялгаатай үзлүүдийг тасралтгүй үргэлжлэн өөрчлөгдсөөр ирсэн эсвэл хамрах хүрээгээр нь авч үзэх нь тустай байдаг.

Зарим теологичдийн нэг буруу үзэл нь Романтик маягын онгодын талаарх үзэл юм. Тэд Ариун Сүнс Библийг бичсэн хүмүүст яг л яруу найрагч эсвэл хөгжмийн зохиолч нарт ордог онгод шиг нөлөөлсөн гэж итгэдэг. Үүнээс болж Шинэ Гэрээнд зөвхөн хүний үзэл бодол нөлөөлсөн гэж үзэхэд хүрдэг. Библийг бичсэн хүмүүс бидний мэдэхгүй зүйлсийг мэддэг, ухаалаг, чадвартай байсан байж болох юм гэж тэд хэлдэг боловч шинэ гэрээ нь бурхан бидэнд юуг ойлгуулж, мэдрүүлж, юунд итгүүлэхийг хүсэж байгааг олж харах найдвартай эх сурвалж биш юм гэж тэд үздэг.

Үүний эсрэг нэг үзэл нь зарим теологичид Механик маягийн онгод гэдэг зүйлд итгэдэг. Энэ үзлийн дагуу Библийг бичсэн хүмүүс өөрийн ухаан байхгүй зөвхөн Ариун Сүнсний бич гэсэн зүйлийг бичсэн гэсэн үг. Энэ үзэл Шинэ Гэрээний үнэн ба эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч Библийг бичсэн хүмүүсийн оролцооны чухал ач холбогдлыг няцаадаг гэсэн үг юм.

Харин эцсийнх нь ихэнх Христитгэгчдийн итгэдэг Сүнсээр хөтлөгдсөн Органик онгодын тухай үзэл юм. Энэ нь Бурханы Сүнс болон Библийг бичсэн хүмүүсийн оролцоог салгах боломжгүй гэж үзэх үзэл юм. Өөрөөр хэлбэл Библийг бичихдээ Ариун Сүнсэнд хөтлөгдөн бичсэн буюу Ариун Сүнс тэднийг чиглүүлсэн. Библийн үг бол Бурханы үг мөн бөгөөд бас Ариун Сүнс тэдгээр Библийг бичсэн

ОНГОДЫН ТӨРЛҮҮД



МЕХАНИК
(Бүрхан хэлсэн)
(Бүрханы бичсэн)

РОМАНТИК
(Бүрхан нөлөөлсөн)

ОРГАНИК
(Бүрхан

хүмүүсийн зан чанар, туршлага, үзэл баримтлал болон бодол санаагаар дамжуулан үгээ хэлсэн гэдэгт итгэдэг гэсэн үг. Тиймээс Библийн үг бол бас бичсэн хүмүүсийнх нь үг мөн. Энэ үзэл бол Бурханы онгодоор бичигдсэн гэдэг ойлголтыг Библи өөрөө гэрчилснийг хамгийн зөвөөр тайлбарласан үзэл гэж болно.

“Органик онгод” гэдэг нь Библи тэнгэрээс бидний өвөр дээр унаад ирчхээгүй эсвэл Библийн зохиолчид зөвхөн сонссон зүйлээ бичээгүй гэсэн үг юм... Харин тэд Библийг бичихдээ Ариун Сүнсэнд хөтлөгдсөн гэсэн үг. Өөрөөр хэлбэл Библи бол Бурханы үг мөн хэдий ч жинхэнэ нөхцөл байдал болон хүний илэрхийллийн

тусгал бас мөн. Ингэж хэлэхээр хүмүүсийн урам жаахан хугардаг. Тэд Бурхан ба хүний хоорондох шууд харилцааг илүү их хүсдэг байх л даа. Гэхдээ энэ бол Бурхан болон хүний хамтын тусгал гэж ойлгох нь бидэнд илүү тустай байдаг. Учир нь би Библийг уншихдаа энэ бол Бурханы үг гэдгийг мэднэ. Мөн үүний зэрэгцээ энэ Бурханы үг хэдий ч миний туулж буй зүйлсийг ойлгодог, надтай адилхан зүйлийг мэдэрдэг хүн энэ үгийг бичсэн гэдгийг бас мэднэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ бол хүнийг бүрэн тусгасан хэр нь Бурханы онгодоор бичигдсэн үг юм. Энэ нь үг бүрчлэн бичүүлсэн үг биш, хүний мэдэрч туулдаг бүхэнтэй холбоогүй үг биш. Тиймээс “Органик онгод” гэдэг нь хүний зан чанар болон бодит нөхцөл байдлаар дамжин бичигдсэн гэсэн үг. Тэд өөрсдийн туулж буй амьдралын туршлага, ойлголт болон хүсэл тэмүүлэл дундаас Бурханы мэдээг бидэнд дамжуулан бичсэн юм.

— Рев. Рик Родхивер
Грейс Эвангеликал Чөлөөт Сүм. Ла Мирана хот

Жишээ нь, элч Петр 2 Петр 3:15-16-р эшлэлд юу гэж бичсэнийг дахин харцгаая:

Хайрт ах Паул маань өгөгдсөн мэргэн ухааныхаа дагуу та нарт бичсэнчлэн ... Захидлуудад нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг бөгөөд юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж ... (2 Петр 3:15-16).

Паул Бурханы Сүнсний онгодоор захидлуудаа бичсэнийг Петр хүлээн зөвшөөрсөн тухай бид өмнө нь ярьсан. Гэхдээ Петр энэ бол Сүнсээр хөтлөгдсөн Органик онгод байсныг бас дурдсан байгааг анзаарах хэрэгтэй. Петр “захидлууд нь ойлгоход хэцүү зарим зүйл байдаг” гэж бичихдээ Паулын уг гарал, хувь хүний зан чанар болон бичих хэв маягийг хэлсэн нь лавтай. Энэ бол Паулын шашны боловсролын талаар хэлсэн хэрэг юм. Мөн Паулын теологийн нарийн төвөгтэй хэллэг Галилаас гаралтай энгийн загасчин байсан Петрт ч хэцүү санагдсан биз ээ.

Шинэ Гэрээний теологийн тухай үзэхдээ бид Петрийн энэ үзэл бодлыг үлгэр жишээ болгох хэрэгтэй. Библийн теологийн үзэл бол Бурханы амьсгалснаар бичигдсэн гэдгийг бид үргэлж санах нь зүйтэй. Бурханы үг учраас Библийн үг бол үнэн бас найдвартай. Гэсэн хэдий ч бид Шинэ Гэрээний теологийг судлахдаа бичсэн хүмүүсийнх нь тухай болон тэдний бодол санааг сайтар ойлгохоор чармайл нь чухал юм.

Үнэндээ Органик онгодын тухай ойлголтын нэг чухал нөлөө нь Шинэ Гэрээний теологийг судлахад ихээхэн ач холбогдолтой. Хэрэв бид Романтик эсвэл Механик маягийн онгод дээр тулгуурлавал нэг бол үгийн эрх мэдлийг, үгүй бол

хүний оролцоог үгүйсгэх болдог. Харин Органик онгодын тухай ойлголт нь Шинэ Гэрээний теологийг дор хаяж гурван түвшинд судлах шаардлагыг бий болгодог.

Гол бөгөөд хамгийн ойлгомжтой түвшин бол бичээс өөрөө. Ил тодорхой хэлсэн санаа нь бидэнд Шинэ Гэрээний теологийн талаар хамгийн сайн ойлголтыг өгч чадна.



Органик онгодын тухай ойлголт нь Шинэ Гэрээний теологийг дор хаяж гурван түвшинд судлах шаардлагыг бий болгодог

Харин бичээсний цаадах түвшинд бид Шинэ Гэрээг бичсэн хүмүүсийн далд, бичигдээгүй, теологийн таамгуудыг судлах хэрэгтэй болно. Үүний тулд тэдний уг гарал болон теологийн итгэл үнэмшлийг нь мэдэх шаардлага зайлшгүй тулгарна. Өөрөөр хэлбэл тэдний нөхцөл байдал болон итгэл үнэмшил нь бичсэн зүйлсэд нь хэрхэн нөлөөлснийг мэдэхийг хичээх нь зүйтэй.

Гурав дахь түвшинд бид мөн л зохиолчийн гол зорилго ухаж ойлгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл тэд уншигчдадаа юу ойлгуулахыг хүссэн юм бол? Олон тохиолдолд Шинэ Гэрээг бичсэн хүмүүс зарим талаар уншигчдадаа онцгой нөлөө үзүүлэхийг зорьсон байдаг. Гэхдээ тэд ихэнхдээ уншигчид нь тэдний бичсэн зүйлийн нөлөөг ойлгоосой хэмээн хүссэн байдаг.

За ингээд харахад Шинэ Гэрээг судлахдаа ил тодорхой санаа буюу бичээсийг ойлгохын хажуугаар теологийн таамаг болон зохиолчийн гол зорилгыг орхигдуулахгүй хамтад нь ойлгох нь амар биш байгаа биз ээ. Ихэнхдээ бид нарийн анхааралтай судлах л шаардлагатай болно. Гэвч Органик онгодын тухай ойлголт нь Шинэ Гэрээний теологийг дор хаяж дээрх гурван түвшинд судлахыг биднээс зайлшгүй шаардана.

За бүгдээрээ Шинэ Гэрээний Органик онгодын талаар тайлбарлаж тодрууллаа. Одоо Шинэ Гэрээний Бичвэрүүдийн эрх мэдлийн тухай тодруулж, өнөө цагт бид тэр эрх мэдэлд хэрхэн хандах ёстойгоо мэдэж авцгаая.

Эрх мэдэл

Евангелийн Сайнмэдээг баримтлагчид бүгд Шинэ Гэрээ тэдний амьдралд эрх мэдэлтэй гэдэгт итгэдэг. Гэхдээ бид тэр эрх мэдэл хаанаас гаралтайг ойлгоход анхаарлаа хандуулах хэрэгтэй. Харамсалтай нь олон сайн итгэгчид Шинэ Гэрээ бол тэдэнд шууд хандаж бичигдээгүй гэдгийг мартах нь бий. Өөрөөр хэлбэл Шинэ Гэрээ бидний төлөө бичигдсэн боловч шууд бидэнд хандаж бичигдээгүй юм. Шинэ Гэрээг хоёр мянга гаруй жилийн өмнө тэр цаг үед амьдарч байсан хүмүүст хандаж бичсэн гэдгийг бид мэддэг хэр нь Шинэ Гэрээний эрх мэдэл амьдралд маань ямар нөлөөтэй байхыг ойлгохдоо энэ үнэнийг орхигдуулдаг. Тиймээс бид Шинэ Гэрээний теологи нь өнөөгийн Христийн дагалдагчдын амьдралд бүрэн дүүрэн хэрнээ шууд бус эрх мэдэлтэй гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Шинэ Гэрээний бичээс нь анхны уншигчдадаа ямар утга учиртай байсныг ойлгоход бид үргэлж бэлэн байх ёстой.

“Христийн дагалдагчид Шинэ Гэрээг анх уншиж эхлэхдээ үндсэн сургаал зааврыг нь л судалдаг. Тэд “Есүс бол Их Эзэн”, “Гэмээсээ эргэж Сайнмэдээнд итгэ”, “бие биеэ хайрла” гэх мэт үндсэн сургаал ойлголтуудыг л анхаарч уншдаг. Тухайн ном бичигдсэн түүхэн нөхцөл байдал эсвэл зохиолчийнх нь уг гарал болон зан чанарыг анхаарч үздэггүй. Тэд үндсэн сургаал ойлголтуудыг хэзээ ч өөрчлөгдөшгүй үнэн гэж хүлээж авдаг хэдий ч Шинэ Гэрээний эрх мэдэлд захирагдах нь ямар хэрэгтэй тухай бараг л хайхардаггүй гэхэд болно. Харин бид Шинэ Гэрээний теологийг судлах тусам амьдралдаа эрх мэдлийг нь зохистойгоор хэрэгжүүлэхийн тулд Шинэ Гэрээний бичээснүүдийн бичигдсэн нөхцөл байдлыг анхааралтай судлахаас өөр гарцгүй гэдэг нь улам бүр тодорхой болдог. Бид зохиолчийнх нь уг гарал, нөхцөл байдал болон санаа зорилгыг ойлгох хэрэгтэй. Гагцхүү тэгж байж л бидний амьдрал дахь Шинэ Гэрээний эрх мэдэлд зохистойгоор захирагдаж чадна.”

Яахын аргагүй урган гардаг асуултуудын нэг бол өөр хүмүүст зориулан бичсэн Шинэ Гэрээг бидний амьдралд эрх мэдэлтэй гэж үзэж болох уу? Тэгэхээр юуны өмнө Шинэ Гэрээ бол үнэн зөв бас гэрээг хүчин төгөлдөр болгох хүч чадалтай гэдэг утгаараа эрх мэдэлтэй юм. Анхны уншигчид болон өнөөгийн уншигчдын хооронд хоёр төрлийн холбоо буюу адил төстэй зүйл бий. Эхнийх нь Шинэ Гэрээний тэнгэрлэг зохиолч нь өчигдөр, өнөөдөр, мөнхөд хэвээрээ. Өнөөдөр ч бид Түүнтэй харилцаатай болох хэрэгтэй хэвээрээ. Удаах нь Есүс Христийн дагалдагч болсон учраас бид Бурхантай гэрээтэй ард түмний нэгэн хэсэг болсон. Тиймээс тэр ард түмний бас нэгэн хэсэг буюу хэдэн зууны өмнө амьдарч байсан хүмүүст хандан хэлсэн үг бидний Их Эзэн Есүс Христээр дамжуулан Бурханы гэр бүлд тэдэнтэй хамт нэгдсэн бидэнд ч бас хамаатай болсон.

— Др. Глэн Г.Скоржи
Бэтэл Библийн Их Сургууль. Сан Диего хот

Энэ харьцуулалт бидний бодол санааг цэгцэлж өгөх нь лавтай. Нэгээс олон хүүхэдтэй эцэг эхчүүд хэрхэн хүүхдүүдийнхээ дээр ихэнхдээ шууд бус боловч бүрэн дүүрэн эрх мэдэлтэй байдгийг сайн мэднэ. Эцэг нь үгэнд нь ороогүй хүүгээ загнаж байна гэж бодъё л доо, “Өрөөндөө орж хийсэн зүйлээ сайн бод” гэж тэрээр хүүдээ хэлжээ. Мэдээж хүүгийн охин дүү нь одоохондоо загнуулаагүй учраас тоглоомоороо тоглоод үлдэнэ. Тэр охин өөрийг нь загнаагүй гэдгийг сайн мэднэ. Гэвч хэрэв охин хэсэг хугацааны дараа бас үгэнд орохгүй бол “Ах чинь загнуулсныг чи харсан биз дээ” гэж загнуулна шүү дээ. Яг ийм нөхцөл байдалд эцэг эх бүр нэг хүүхдийнх нь алдаанаас нөгөө хүүхэд ч нь бас суралцаасай гэж хүсдэг. Энэхүү шууд бус эрх мэдэл нь эхэлж загнуулаагүй байж болох ч хэрхэн байх ёстойг бүх хүүхдүүдэд нь зааж байдаг.

Үүнийг л Органик онгод нь өнөөгийн Христийн дагалдагч нарын амьдралд Шинэ Гэрээний шууд бус ч бүрэн дүүрэн эрх мэдэлд хөтөлнө гээд байгаа юм. Шинэ Гэрээний бичээсүүд анхны хүлээн авагчдад шууд ба бүрэн дүүрэн эрх мэдлээр үгээ хэлсэн. Мөн өнөөдөр ч тэдгээр үгс бүрэн дүүрэн эрх мэдэлтэй хэвээр байгааг бид мартаж болохгүй. Тиймээс Христийн итгэмжтэй дагалдагч нар Шинэ Гэрээнд захирагдах эсэхдээ хэзээ ч эргэлзэх учиргүй юм. Харин тэр эрх мэдэлд хэрхэн захирагдах ёстойгоо мэдэх хэрэгтэй. Үүнийг мэдэхийн тулд бид тухайн үг бичигдсэн нөхцөл болон анхны зорилгыг сайтар судлах нь зүйтэй.

Бурханы үгийн талаар оюутнуудын байнга асуудаг нэг асуулт бол 2000 жилийн өмнө амьдарч байсан хүмүүст хандсан үг бидэнд яагаад хамаатай юм бэ гэдэг асуулт юм. Одоо энэ үг нь бидэнд хандсан эсвэл зориулсан Бурханы үг байж болно гэж үү? Харин энэ асуулт бол гол түлхүүр нь гэж би боддог. Энэ нь хэдийгээр Бурханы бидэнд хандсан үгс биш гэж харагддаг ч гарцаагүй бидэнд зориулсан үг мөн билээ. Библийн ном бүрд, уран зохиолын төрөл болон нөхцөл байдал зэргээс үл хамааран нэг л нийтлэг зүйл байдаг нь Библийн ном бүр нь Бурханы мөн чанар буюу Бурхан гэж хэн бэ? гэдгийг илчлэн таниулдаг. Мөн бид Бурхантай харилцах харилцаандаа чухам хэн болохыг маань илчилдэг. Энэ дэлхий дээрх бидэнд хандсан Бурханы зорилго төлөвлөгөөг илчилж, Бурханд болоод бусад хэрхэн хариу үйлдэл үзүүлэх ёстойг харуулдаг. Тиймээс үнэндээ Бичвэрээс бидний хамгийн гол мэдэж авдаг зүйл бол Бурханы зүрх сэтгэл гэж хэлж болно. Бид Бурханы мөн чанар болон зорилгыг олж мэддэг. Тиймээс тэдгээр үгс өөр нөхцөлд байсан, өөр хүмүүст хандан бичсэн учир бидний амьдралд шууд хандаагүй байдаг хэдий ч Бурханы мөн чанар болон зорилгыг, өөрсдийн хэн гэдгийг болон Бурхантай ямар харилцаатай байхыг бид тэндээс л олж мэдэх болно. Тэгэхээр хамгийн гол нь Библи бидэнд Бурханы зүрх сэтгэл болон зорилгыг зааж, Түүнтэй болон өөр хоорондоо ямар харилцаатай байхыг хэлж өгдөг билээ.

— Др. Марк Л. Страус
Бэтэл Библийн Их Сургууль. Сан Диего хот

Жишээ нь, Матай 19:21-р эшлэлд, Есүс нэгэн баян залууд онцгой заавар өгсөн юм:

Чи төгс байхыг хүсэж байвал явж, хөрөнгөө зарж ядууст өг. Тэгвэл чи тэнгэрт эрдэнэстэй болно. Тэгээд ирж, Намайг дага гэлээ (Матай 19:21).

Энэ эшлэлийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ? Бид бүгдээрээ ямар ч амьдралтай байсан хамаагүй “хөрөнгөө зарж ядууст өгөх” ёстой юу? Энэ баян залуу яг хэн байсан болон Есүс түүнд яагаад ингэж хэлснийг ойлгож байж л энэ асуултад үнэн зөв хариулт өгч чадна.

Энэ хүний нэр хэргэм болон Есүстэй харьцаж байгаа байдлыг нь харвал Иудей хүн байсан нь лавтай. Мөн тэр тухайн нийгэмдээ нөлөөтэй, чинээлэг хүн байсан бөгөөд Иудей уламжлалыг чин сэтгэлээсээ дагадаг нэгэн байсан нь ойлгомжтой байна. Өмнөх эшлэлд нь тэрээр Есүсээс “Багшаа, мөнх амийг олохын тулд ямар сайн юм хийх ёстой вэ?” гэж асуухад Есүс “тушаалуудыг сахь” гэж хариулсан байдаг. Тэгэхэд тэр залуу тун бахдалтайгаар бүх тушаалыг дагадаг гэдгээ хэлсэн. Тиймээ Есүс түүний хувьд хамгийн чухал зүйл болох эд баялаг болон нэр нөлөөтэй байр суурийг нь хөндсөн зүйл хэлсэн юм.

Эд хөрөнгөтэй байх нь муу зүйл биш гэдгийг Бичвэрээс бид олонтоо харж болно. Бас Христийн дагахад ч эд хөрөнгө саад болохгүй. Харин мэдээж Есүсийн дагалдагч болсны хувьд Бурхандаа үйлчлэхийн тулд бид хувийн хүсэл сонирхлоо орхиход бэлэн байх ёстой юм.

Үйлс 5:1-11-р эшлэлээс бид Ананиа ба Сапфир хоёрын тухай өөр нэгэн жишээг харж болно. Тэд сүм чуулганд бүх мөнгөө өгнө гэсэн боловч хэсгийг нь өөрсдөдөө нууж авч үлдсэн. Тэд бүх зүйлээ өгөөгүйгээс болж гэм нүгэлд унаагүй бөгөөд тэднийг мөнгөө өгөхийг мөн хэн ч шаардаагүй. Гэвч тэд олон нийтийн дунд нэр хүнд олохын тулд худал хэлснээсээ болж буруудсан юм.

Есүсийн баян залууд хэлсэн хариулт үнэндээ мөнгөтэй огт холбоогүй. Харин Тэрээр тэр залуугийн золиослоход хамгийн хэцүү зүйлийг онилсон. Өөрөөр хэлбэл Есүс түүнийг хамгийн чухал зүйл буюу эд хөрөнгийн тухай ярьснаараа зүрх сэтгэлийнх нь асуудлыг хөндөж чадсан.

Энэ жишээ бидэнд Бичвэрийн эрх мэдэлд захирагдахын тулд тухайн багц эшлэлийн утга агуулга болон анхны зорилгыг нягтлах хэрэгтэйг харуулж байна. Тэгж байж л Есүс яг юу гэж тушаасныг хэрхэн мэдэхээ ойлгох болно.

Шинэ Гэрээ бас Хуучин Гэрээтэй л адил гүн ухааны ном биш ээ. Энэ ном гүн ухааны сургаалуудаас бүрдээгүй, харин хаана ч амархан ойлгогдох хэлбэрээр бичигдсэн юм. Шинэ Гэрээ бол тодорхой бөгөөд түүхэн байдаг. Үүний шалтгаан нь ч ойлгомжтой.

Бурхан Хуучин ба Шинэ Гэрээний аль алианаар нь дамжуулан Өөрийгөө илчилсэн бөгөөд ингэхдээ үргэлж тодорхой бүлэг хүмүүст хандан илчилдэг. Бурхан нийтэд хандан Өөрийгөө илчилдэггүй, тэгвэл хэтэрхий ерөнхий байх тул хэзээ нэгэн цагт хэнд ч хамаагүй болох байсан биз. Бурхан Абрахам, Исаак, Иаков, Мосе, Давид, Исаиа, Иеремиа, дараа нь Есүсээр дамжуулан дагалдагч нар болох Петр, Паул нарт Өөрийгөө илчлэн таниулж байсан. Тиймээс бид тодорхой хүмүүсийн тухай, тодорхой нөхцөл байдлын тухай судлах хэрэгтэй болдог. Бурхан бол Бүтээгч бөгөөд бүтээлүүд нь цаг хугацаа ба орон зайд оршдог. Харин Бурхан Өөрийгөө илчлэхдээ цаг хугацаа болон орон зайд захирагдан илчилдэггүй.

— Др. Экхард Ж.Шнабел
Гордон-Конвел Теологийн Их Сургууль

“Шинэ Гэрээний теологийг яагаад судлах хэрэгтэй вэ?” хэмээх энэ хичээлээрээ бид Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийг ойлгохын тулд Шинэ Гэрээний номуудын түүхэн нөхцөл байдлыг сайтар судлах шаардлагатай тухай үзлээ. Одоо бид өнөө үе олон Шинэ Гэрээний үеийн хооронд хэвээр хадгалагдан үргэлжлэх болон үл үргэлжлэх зарчуудын тухай үзэхэд бэлэн боллоо.

ҮРГЭЛЖЛЭХ БА ҮЛ ҮРГЭЛЖЛЭХ ЗАРЧМУУД

“Та 500 жилийн өмнө зохиогдсон ном унших гэж байна гэж бодъё. Мэдээж таны мэддэг хэлнээс өөр хэлээр бичигдсэн. Тэр номын утга санааг өвөрмөц хэлбэрээр илэрхийлсэн бөгөөд тэнд дурдагдсан ёс заншил, уламжлалууд нь хэт хоцрогдсон. Гэсэн ч та тэр номыг судлах тусам амьдралтай чинь ойр санагдана. Тэр ном олон зуун жилийн өмнө бичигдсэн ч дэлхий ертөнц тэр үед ч өнөө цагаас их ялгаагүй байсан. Танд ойлгогдохооргүй тийм ч харь холын биш байх нь лавтай. Мэдээж бүрэн дүүрэн ойлгоход хичээл зүтгэл шаардах ч энэхүү эртний номын утгыг та ойлгох боломжтой.

Шинэ Гэрээтэй бид бас яг ингэж л харьцдаг. Шинэ Гэрээ 2000 гаруй жилийн өмнө бичигдсэн. Тийм учраас анх бичигдсэн хэл, утга санаа, ёс заншил болон уламжлал нь өнөөгийн орчин цагаас ихээхэн өөр байх нь мэдээжийн хэрэг. Хэдий тийм ч тэдгээр ялгаатай байдлыг хичээнгүйлэн судалбал Шинэ Гэрээ бидний амьдралтай олон талаар холбоотой гэдгийг харах болно.”

Библи 2000 гаруй бичигдсэн гэдэг нь анхаарууштай бөгөөд чухал асуудал мөн. Учир нь энэ нь түүхийн онцгой цаг үед бичигдсэн юм. Гэхдээ энэ бол Бурханы Үг гэдэг нь өнөөдөр ч энэ ном бидний амьдралд хамаатай асуудал. Учир нь Бурхан энэ номоор дамжуулан бидэнд хандсан хайр энэрэл ба нигүүлслээрээ бидэнтэй

ярихаар сонгосон юм. Еврей номд Бурханы Үг бол хоёр талдаа иртэй сэлэм гэж хэлсэн байдаг. Үнэндээ жижигхэн хурц мэс заслын хутгатай илүү адилхан. Тиймээс Бурханы Үг бидний зүрх сэтгэлийг нэвт зүсэн амьдралд маань эрх мэдэлтэйгээр орж ирдэг бөгөөд биднийг зааварчлан сургадаг. Тэр зааврыг нь бид дагах ёстой байдаг. Гэхдээ үүнд зүгээр л дуулгавартай байгаад зогсохгүй үнэн зүрх сэтгэлээсээ хайрлан, зүрхэндээ сийлэн үлдээхийг бидэнд мөн сургадаг юм. Энэ бол Бурханы үг учраас бидэнд одоо ч чухал гэсэн үг юм.

— Др. Жэйсон Оакс
Талбот Теологийн Сургууль

Ингээд бүгдээрээ бидний болон Шинэ Гэрээний хоорондох үргэлжлэх болон үл үргэлжлэх зарчмыг ойлгох нь ямар их тустайг одоо харцгаая. Ингэхдээ бид гурван гол нөхцлийг анхаарах болно. Энэ нь цаг үеийн нөхцөл, соёлын нөхцөл, хувь хүнтэй холбоотой нөхцөл юм. Эдгээр гурван нөхцөл хоорондоо уялдаа холбоотой боловч тус бүрд нь авч үзэх нь илүү ойлгомжтой байдаг. Одоо эхлээд цаг үеийн нөхцөлийн талаарх зарим чухал зүйлсийг авч үзье.

ЦАГ ҮЕ

Библийн түүхийн цаг үе гэж ярихаар бидний санаанд юуны өмнө тэнгэрлэг илчлэл тохиосноороо бусад бүх л цаг үеэс ялгаатай тэр л цаг үеийн тухай орж ирдэг. Мэдээж түүхэн цаг үеийг ангилан хуваах олон арга байдаг боловч ямар ч цаг үе нь урьд ба хожмын цаг үеэсээ эрс ялгаатай байна гэж үгүй. Гэвч бид библийн түүхийг ихэнхдээ Шинэ Гэрээний цаг үе ба Хуучин гэрээний цаг үе гэж хуваадаг.

Бид Шинэ Гэрээний цаг үеийг шинэ гэрээг байгуулсан цаг үе гэж тодорхойлдог. Энэ цаг үе Христийн анхны ирэлтээр эхэлсэн бөгөөд эргэн ирэх хүртэл үргэлжлэх болно. Энэ шинэ гэрээ байгуулсан цаг үе бол Мессиаатай холбоотой тул онцгой юм. Энэ бол Давид хааны агуу удам болох Есүс Бурханыг төлөөлөн хаанчлах цаг үе юм.

Цаг үеийн нөхцөл байдлууд Шинэ Гэрээний теологийг судлах зайлшгүй шаардлагыг хэрхэн бий болгодгийг ойлгохын тулд бид шинэ гэрээ байгуулсан үеийг нэгтгэдэг цаг үеийн үргэлжлэх зарчмуудыг авч үзэх болно. Дараа нь харин үл үргэлжлэх зарчмын тухай үзнэ. Эхлээд үргэлжлэх зарчмуудыг авч үзье.


Үргэлжлэх зарчмууд

Шинэ Гэрээний үеийн болон өнөө үеийн хооронд цаг үеийн үргэлжлэх зарчмууд олон бий. Тэдгээрийн холбоог ойлгох хамгийн сайн арга зам бол өнөөдрийн Христитгэгчид анхны зуунд амьдарч байсан итгэгчдийн үйлчилж байсан тэр л Бурханд үйлчилж байгаагаа ойлгох явдал юм. Уламжлалт системт теологичид ихэвчлэн Бичвэрүүд нь Бурханы хувиршгүй, өөрчлөгдөшгүй мөн чанарын тухай

заасныг онцолдог. Тэд Бурханы ганхашгүй мөн чанар, мөнхийн төлөвлөгөөний тухай буюу Тооллого 23:19, Исаиа 46:10 болон Иаков 1:17 зэрэг эшлэлүүд дэх гэрээний амлалтуудад анхаарлаа хандуулдаг. Бид тэр л хувиршгүй Бурханд үйлчилдэг учраас Шинэ Гэрээнд Өөрийн хүмүүсээсээ хүсдэг байсан зүйлстэй адил зүйлсийг өнөөдөр биднээс ч мөн хүсэн хүлээдэг гэж бид бодох хэрэгтэй. Еврей 13:7-8-р эшлэлийг хамтдаа харцгаая:

Та нарт Бурханы үгийг ярьсан удирдагчдаа сана. Тэдний амьдралын хэв байдлын үр дүнг эргэцүүлж, итгэлийг нь дуурай. Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ (Еврей 13:7-8).

Еврей номын зохиолч уншигчдаасаа “Удирдагчийнхаа амьдралын замналыг санаж итгэлийг нь даган дуурайхыг” шаардсан. Мөн “Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ” гэж хэлснээрээ Бурханы хувиршгүй мөн чанарыг сануулан, энэхүү шаардлагыг нь биелүүлэх урам зориг өгсөн байна. Тэдгээр уншигчид өмнөх үеийн удирдагч нарынхаа итгэлийг үлгэр дуурайл болгохдоо эргэлзэх зүйлгүй байж чадна. Учир нь Есүс хувиршгүй учир тэд адилхан үр дүнд хүрэх нь ойлгомжтой байсан юм.



Өнөөдрийн Христ итгэгчид анхны эцүнд амьдарч байсан итгэгчдийн үйлчилж байсан тэр л Бурханд үйлчилж байгаа.

Шинэ Гэрээний итгэгчдийн л нэгэн адил бид гэм нүглийн эцсийн төлөөс болсон Христийн үхлээр амьдарч байгаа. Бид анхны зууны итгэгчдийн л адил Христийн амиллаар Түүнтэй хамт амилуулагдсан. Мөн бид Бурханы Сүнс Хуучин Гэрээний үед байгаагүй ихээр бууж ирсэн тэр л цаг үед амьдарч байна. Есүсийн заасан бүхнийг дэлхийн өнцөг булан бүрд түгээх яг ижилхэн үүрэг зорилготой Христийн биеийн нэгэн хэсэг бид мөн. Шинэ Гэрээний цаг үеэс бид түүхэн цаг хугацаагаар алс хол зайтайг эс тооцвол эдгээр олон үе дамжин ирсэн үргэлжлэх зарчмуудыг хувиршгүй Бурхан бий болгосон учраас бид Шинэ Гэрээг өнөөгийн амьдралдаа хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм.

Тэгэхээр бүгдээрээ Шинэ Гэрээний үе ба өнөө үеийн хооронд оршсоор буй зарим нэг цаг үетэй холбоотой нөхцөлүүд болох үргэлжлэх зарчмуудын тухай авч үзлээ. Тэгвэл одоо шинэ гэрээний цаг үе дэх үл үргэлжлэх зарчмын тухай үзье. Мэдээж Шинэ Гэрээний теологийг анхааралтай судлах энэ нь заавал шаардлагатай зүйл шүү дээ.

Үл үргэлжлэх зарчмууд

Шинэ Гэрээний үе болон өнөө үеийн хоорондох цаг үеийн үл үргэлжлэх зарчим нь Хуучин Гэрээний үе болон өнөө үеийн хоорондын үл үргэлжлэх зарчимтай харьцуулахад тийм ч их бишээ. Гэхдээ л бид Шинэ Гэрээг судлах бүртээ санаж байх зайлшгүй хэрэгтэй хэдэн онцгой ялгаа бий. Ефес 2:20-р эшлэлд элч Паул чухал нөлөө бүхий цаг үеийн үл үргэлжлэх зарчмаас нэгийг нь дурдсан байдаг:

[Сүм чуулган бол] элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ (Ефес 2:20).

Энд Паул элч нар болон эш үзүүлэгчид Есүс Христтэй хамт сүм чуулганы суурийг тавьсан үе болон сүм чуулганы хойч үеийн хоорондох ялгааг гаргаж өгсөн юм.

Энэ хичээлийн эхэнд дурдсанчлан сүм чуулган 2000 жилийн туршид сүм чуулганы суурь болсон Христ болон Түүний элч нар, эш үзүүлэгчдийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөөр ирсэн. Гэхдээ мэдээж тэд одоо бидэнтэй хамт байхгүйг бид бас мэднэ. Энэхүү бодит нөхцөл байдал Шинэ Гэрээний үе болон өнөө үеийн бидний амьдралын хооронд олон тооны үл үргэлжлэх зарчмуудыг бий болгодог.

Эхнийх нь, Есүс болон Түүний элч, эш үзүүлэгч нарын үйлдэж байсан баталгаа харуулсан гайхамшигт олон жишээг Шинэ Гэрээнд дурдсан байдаг. Гайхамшигийг үйлдэх тэр чадвар нь Есүс болон Түүний элч, эш үзүүлэгчдийг эрх мэдэлтэй бөгөөд сүм чуулганы суурийг тавьсан удирдагч нар болгосон юм. Бурхан өнөөдөр ч сүм чуулганд гайхамшгаа үйлдсээр байгаа ч сүм чуулганы шинэ удирдагчийг тэдгээр гайхамшгуудын үндсэн дээр томилдоггүй. Харин өнөөдөр ч сүм чуулган дахь эрх мэдлийг Шинэ Гэрээний жишгээр тогтоосон хэвээр байгаа. Тийм ч учраас тэдгээр жишгүүдийг өнөөдөр хэрхэн ашиглах ёстойг бид анхааралтай судлах хэрэгтэй байдаг билээ.

Хоёрдугаарт, Шинэ Гэрээний үед Есүсийн элч нар болон эш үзүүлэгчтэй шууд харьцах боломжтой байсан. Тэр үеийн Христитгэгчид элч нар болон эш үзүүлэгчдээс заавар зөвлөгөө, асуултын хариултаа шууд авах боломжтой байв. Жишээ нь бид 1 ба 2-р Коринт болон Филемон зэрэг номд Паул Христийн дагалдагч нарын хүсэлтэд хариулт өгсөн байдгийг бид харж болно. Үүнээс гадна Шинэ Гэрээний үед сүм чуулганыг хамарсан томоохон асуудлуудыг сүм чуулганы суурийг тавьсан, Иерусалимын зөвлөлд буй удирдагч нараас асууж шийддэг байсныг Үйлс 15-р бүлгээс харж болно. Гэвч өнөөдөр бидний дунд тийм эрх мэдэлтэй удирдагч нар байхгүй. Тиймээс Шинэ Гэрээг нарийвчлан судалж амьдралдаа хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгтэй болсон юм.

Гуравдугаарт, Шинэ Гэрээний теологийг судлаж байхдаа бид сүм чуулганы суурийг тавьж байсан тухайн цаг үедээ онц ач холбогдолтой байсан Шинэ Гэрээг бичсэн хүмүүсийн теологийн тухайн үеийн үзэл баримтлалууд нь өнөөгийн бидэнд төдий л хамаагүй гэдэг үнэнтэй нүүр тулахаас өөр аргагүй болдог.

“Бурханы хүмүүс Хуучин Гэрээний үеэс Шинэ Гэрээний итгэл үнэмшил рүү шилжиж байсан тэр л онцгой цаг үед Шинэ Гэрээ бичигдсэн юм. Энэ шалтгааны улмаас Христийн дагалдагч нар Хуучин Гэрээний зан үйл болон Иудейн ёс уламжлалтай хэрхэн харьцах ёстой тухай олон асуудлууд Шинэ Гэрээнд бичигдсэн. Христитгэгч эрчүүд хөвч хөндүүлэх ёстой юу? Тэд Иудейн цэвэр, бузар хүнсний

хуулийг дагах ёстой юу? Христ гэм нүглийн төлөөсийг төлсөн учир одоо Христэд итгэгчид сүмд амьтнаар тахил өргөх ёслолыг үргэлжлүүлэн үйлдэх талаар ямар ойлголттой байх хэрэгтэй вэ? Иудейн баяр ёслол болон тэмдэглэлт өдрүүдийг сүм чуулганы амьдралдаа хэрхэн хослуулах вэ? Мэдээж эдгээр үндсэн теологийн асуудлууд эрт дээр үед ихэнх нь бүрэн шийдэгдсэн. Шинэ Гэрээ байгуулагдсан энэхүү үндсэн суурь үе шувтармагц Христийн сүм чуулган өөр асуудлуудтай золгосон билээ.

Шинэ Гэрээг уншихдаа бид цаг үеийн үл үргэлжлэх зарчмуудыг ялган танихад бэрхшээлтэй байдаг. Гэхдээ бид Шинэ Гэрээн дэх тэдгээр эртний теологийн маргаантай асуудлуудын хариултуудыг өнөөдөр ойлгож хэрэгжүүлэхийг хүсвэл тэдгээр үгсийг судлахад хүчин чармайлт гаргаж анхаарал болгоомжтой байх хэрэгтэй.

Мэдээж Библийг уншихдаа анхнаасаа хэрхэн бичигдсэн чигээр нь унших нь чухал байдаг. Тэгээд уншиж байхдаа бид тэнд бичигдсэн олон асуудлууд өнөөдрийн бидний тулгарч буй асуудалтай адилгүй гэдгийг заримдаа анзаардаггүй. Жишээ нь: Хуучин Гэрээнд байдаг бүх гэрээний асуудлууд Израилтай холбоотой байдаг. Тэд ийнхүү хуучин гэрээний дор амьдарч байтал Христ ирэх цаг буюу тэр гэрээ нь биелэх цаг болсон нь сүм чуулганд хамгийн гол теологийн асуудал болсон. Одоо тэгвэл хуучин гэрээний шаардлагуудад яаж хандах вэ? Эдгээр нь сүм чуулганд хэрхэн биеллээ олсон бэ? Иудей ба харь үндэстнүүд хэрхэн харилцах вэ? Үнэндээ бид ингэж хэлдэг ч ихэнхдээ ийнхүү ангилан бодож чаддаггүй. Тиймээс бид эхлээд Бичвэрийг сайтар нухацтай судалж, яг өөрийнх нь үг хэллэг, хам сэдэв, хэлбэр маяг, илэрхийлэмжийг ойлгон, гэрээний утга учрыг болон Христ дотор энэ нь хэрхэн биелснийг судалж мэдээд тэгээд дараа нь бидэнд энэ нь ямар хамаатай болохыг эргэцүүлэн бодож эхлэх хэрэгтэй.

— Др. Стефен Ж. Вэллум
Өмнөд Баптист Теологийн Их Сургууль

Цаг үеийн нөхцөл дэх үргэлжлэх зарчмууд болон үл үргэлжлэх зарчмуудыг авч үзлээ. Одоо соёлын нөхцөлтэй холбоотой зүйлсээс цөөн хэдийг авч үзье.


Соёл

Соёл гэж ярихаар бидний санаанд хамгийн түрүүнд хүний нийгмийн нэгдсэн ойлголт, зан дадал эсвэл сэтгэл мэдрэмжтэй холбоотой хэв маягууд орж ирдэг. Соёл нь уран зураг, загвар, технологи, улс төрийн бүтэц болон хүний өдөр тутмын харилцааны хэв маяг гэх мэтээр илрэн гардаг. Бид Шинэ Гэрээний теологийг судлах үедээ анхны зууны үе болон өнөө үеийн аль алиных нь амьдралын эдгээр соёлын талуудыг анхаарахгүй өнгөрч болохгүй.

Соёлын нөхцөлүүдэд анхаарал хандуулах бүрдээ бид мөн л соёлын үргэлжлэх болон үл үргэлжлэх зарчмуудыг авч үзэх хэрэгтэй. Заримдаа энэ нь тийм ч амар ажил биш байдаг. Тиймээс одоо соёлын нөхцөлтэй холбоотой үргэлжлэх зарчим нь хэр бодитой болохыг эхлээд авч үзье.

Үргэлжлэх зарчим

Соёл бүр ялгаатай гэдгийг бид бүгд мэдэх бөгөөд түүхэн цаг хугацаа болон газар зүйн байршлын зайнаас хамааран ялгаа нь ихэсдэг гэдгийг ч ойлгодог. Гэхдээ хэчнээн ялгаатай ч үнэндээ бүх соёл нэг л дэлхий дээр оршин байдаг болохыг бид мартаж болохгүй. Энэ хүчин зүйл нь цаг хугацаа болон газар зүйн ялгааг даван туулж чадсан соёлын үргэлжлэх зарчмуудыг бий болдог. Газар дэлхий дээрх соёл бүр хүн



Хүн төрөлхтний соёл харилцан адилгүй ч нэг л газар дэлхий дээр оршдог.

төрөлхтний мөн чанар болон бодит, хүрээлэн буй байгалийн нөлөөгөөр онцгой хэв маягаа олж байдаг. Тэгэхээр эдгээр нөлөөлөгч хүчин зүйлс нь төстэй байх тусам соёлын хэлбэр нь ч төстэй байх нь олон. Энэ тухай Номлогчийн Үгс 1:9-р эшлэлд ийнхүү өгүүлсэн байдаг:

Байсан юм бахь байдгаараа. Хийсэн юмаа хийдэг л хэвээрээ. Наран доор нэг ч шинэ юм алга (Номлогчийн Үгс 1:9).

Амьдрал ийм ч учраас бид өнгөцхөн ялгааны цаана Шинэ Гэрээний үе болон өнөө үеийн хооронд соёлын олон ижил төстэй зүйлс байгааг хараад гайхах зүйлгүй юм. Өнөөдөр ч хүмүүс Шинэ Гэрээний үеийн хүмүүс шиг хувцсандаа анхаарч, урлаг таашааж, гэр бүлтэй болж, засгийн газар байгуулж, гэмт хэрэгтнийг яллах зэрэг зүйлсийг хийсэн хэвээр л байгаа. Тиймээс анхны зуун болон өнөө үеийн соёлыг харьцуулахад ижил төстэй талуудыг олж харахад амархан.

Нэг жишээ авч үзье, Иохан 4:6-7-р эшлэлд Есүс нэгэн Самари эмэгтэйтэй ярилцсан үйл явдлыг дүрсэлсэн байдаг.

Энэ нь зургадугаар цагийн орчим байв. Самарийн нэгэн эмэгтэй ус татахаар тэнд ирэхэд Есүс түүнээс —Надад уух юм өгөөч гэв. (Иохан 4:6-7).

Энэ үйл явдлын соёлын нөхцөлийн талаарх тайлбаруудыг бид олонтоо сонссон биз ээ. Есүсийн тэр цаг үед Иудейчүүд Самари хүмүүсийг “цэвэр биш” гэж үздэг байсан тул огт харилцдаггүй байсан ч Есүс тэр Самари эмэгтэйтэй ярилцсан байдаг.

Бидний цаг үед үүнийг уншаад үнэндээ Самари хүний тухай ойлголт байхгүй болохоор юу ч мэдрэхгүй. Өнөө цагт хүмүүсийг цэвэр эсвэл цэвэр биш хэмээн бид огт боддоггүй. Гэхдээ л Библийн энэ үйл явдал болон өнөө цагийн нийгмийн гадуурхал хоёрын хооронд анхаарал татахуйц төсөөтэй зүйлсийг олж харж болно. Энэ талаас нь авч үзвэл өнөөгийн хүмүүс анхны зуунд амьдарч байсан хүмүүсээс ялгарах юмгүй юм. Бас бид анхны зуунд амьдарч байсан хүмүүсийн амьдарч байсантай л адилхан нийгэмд амьдарч байгаа учраас ихэнх тохиолдолд орчин үеийн соёлын туршлагаудаас ялгаатай талуудыг нь үл хайхран төсөөтэйг нь төвөггүйхэн олж чадна.

Соёлын нөхцөлийг харгалзан үзэхдээ бид өнөөгийн болон Шинэ Гэрээний үеийн хоорондох үргэлжлэх зарчмууд нь хэр чухал болохыг үзлээ. Үүнтэй адил Шинэ Гэрээний теологийн тухай ойлголтод маань соёлын үл үргэлжлэх зарчмуудыг бид мөн мэддэг байх ёстой.

Үл үргэлжлэх зарчмууд

Бичвэр бол Бурханы үг, харин жинхэнэ зохиолч нь Ариун Сүнс гэж бид ойлгодог. Бичвэрийг ихэнхдээ ийнхүү өндөрт өргөн ярьдаг учраас мэдээж заримдаа нэг асуулт урган гарна. Тэгвэл яагаад бидэнд Бичвэрүүдээс өөр зүйл хэрэгтэй байдаг юм бэ? Яагаад соёл, нөхцөл байдал, хэл зэргийг нь бас судлах ёстой юм бэ? Бидэнд байгаа Бичвэрүүд нь Бурханы Үг юм бол тэгээд хангалттай юм биш үү? Ариун Сүнс бол жинхэнэ зохиолч нь гэж бид мэднэ. Гэхдээ Ариун Сүнс Бичвэрийг хүнээр дамжуулан, түүхэн хам сэдэвтэй нь бидэнд өгсөн юм. Бичвэр бол бидэнд өгсөн зүгээр нэг нотлогдсон үнэний жагсаалт биш. Бидэнд байгаа Бичвэр бол юу хийх ёстой болон хийх ёсгүйг заасан багц хуулийн ном биш. Эсвэл хааяа үнэн үг хэрэгтэй болохоор эш татдаг зүйр цэцэн, онч мэргэн, сургаалт үгсийг багтаасан түүвэр эмхэтгэл биш. Харин дээрх бүхэн нь тодорхой хэмжээгээр Бичвэрүүдэд байдаг ба энэ нь Бурханы илчлэл бөгөөд Бурханы илчлэл нь түүхэн дэх Бурханы хийдэг үйлс юм. Заримдаа бид энэ бүхнийг нэгтгээд Бичвэр бол түүхийн туршид хүмүүсийн үгээр дамжуулан бичсэн Бурханы Үг юм гэж дүгнэн хэлдэг. Харин “түүхийн туршид” гэдэг үг бидэнд маш чухал. Хэрэв бид Бичвэрүүдийн бичигдсэн соёлын хам сэдэв болон хэлийг нь ойлгохгүй бол үүнийг амархан буруу тайлбарлах боломжтой.

— Др. Эдвард М. Кеазириан
Гордон-Конвел Теологийн Их Сургууль

Үнэндээ энэ цаг үеийн болон Шинэ Гэрээний цаг үеийн соёлын олон ойлголтууд асар их ялгаатай байдаг. Тиймээс бид Шинэ Гэрээний теологийг

тайлбарлаж хэрэгжүүлэхэд эдгээрийн учруулах саад бэрхшээлийг даван туулахад ихээхэн хүчин зүтгэл гаргах хэрэгтэй.

Соёлын үл үргэлжлэх зарчмуудын хамгийн тод нэг жишээ бол Шинэ Гэрээг бичсэн хэл юм. Өнөөдөр Шинэ Гэрээг бичсэн эх хэл болох Грек хэл дээр нь уншиж ойлгох Христийн дагалдагчид харьцангуй цөөхөн болсон нь мэдээж.

Цаашилбал бид анхны зууны үеийн утга зохиолын онцлог болон Шинэ Гэрээг бичсэн хүмүүсийн ашиглаж байсан Хуучин Гэрээний Еврей, Грек хэл дээрх хувилбаруудын нөлөө зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Мөн тухайн цаг үеийн улс төр, эдийн засаг болон өргөн хүрээний нийгмийн дадал хэвшлийг үл ойшоодгоо болих ёстой. Бид эдгээрийг хичээнгүйлэн биелүүлж чадвал Шинэ Гэрээний үеэс өнөө үе хүртэлх соёлын үл үргэлжлэх зарчмуудыг илүү сайн ойлгож чадах юм.

Лондон хотын галт тэрэгний өртөөнд “Зайг анхаарна уу” гэсэн анхааруулах дохио байдаг. Та галт тэрэгнээс буух үед галт тэрэгний хаалга болон зорчих тавцан хооронд том зай байдаг. Тиймээс та “Зайг анхаарна уу, зайг анхаарна уу” гэдэг анхааруулгыг байнга сонсох болно. Шинэ Гэрээний соёлын нөхцөл байдлыг ойлгох нь яагаад чухал вэ? гэдгийг санаж байхад маань бас энэ дохио тус болох байх. Учир нь одоо болон өнгөрсний хооронд асар том зай байгаа шүү дээ. Ашиглаж байсан хэлний хооронд маш том зай бий. Мөн нийгмийн байр суурь, хаант засаг гээд бидний ойлголтод маш том зайтай. Мэдээж одоогоос 2000 жилийн өмнөх амьдрал болон өнөөдрийн амьдрал хоёр бараг бүх л талаараа асар их зайтай байгаа шүү дээ. Хэрэв бид тэр зайг анхаарахгүй бол нэг л мэдэхэд тэр зайг өөрсдийн соёл, өөрсдийн юмсыг үзэх үзлээр нөхөх гэж оролдох болно. Бичвэр нь өнөөдөр бидний амьдралд хэрхэн хэрэгжиж болохыг мэдэхийн тулд үүнийг анхааралтай судлахын оронд бид эсрэгээр нь хийж орхидог. Бид бичвэрийг ойлгодог хэв маягтай болчихдог. Бид бичвэрийг бидэнд хандан яриулахын оронд өөрсдөө бичвэрт хандан ярьдаг. Тэгээд л бид зарим зүйлийг орхигдуулчихна... Хэрэв бид энэхүү эх мэдээ нь онгод оруулагдсан хэмээн итгэдэг юм бол Бурханы Үгийг сонсохын тулд тэрхүү зайг анхаарахыг хичээх учиртай. Үгүй бол бид өөрсдийн нийгмийн нөхцөлөөр бичвэрийг дүгнэх аюултай.

— Др. Марк А. Женнингс.
Гордон-Конвел Теологийн Их Сургууль

За цаг үеийн болон соёлын нөхцөлүүдийн үргэлжлэх зарчмууд болон үл үргэлжлэх зарчмуудыг авч үзлээ. Харин одоо Шинэ Гэрээг судлахын тулд хувь хүний нөхцөлүүдийг судлах нь яагаад чухал болохыг үзэцгээе.

ХУВЬ ХҮН

-20-

“Бид бүгдээрээ амьдралын туршлагаараа харахад хүн бүр өөр гэдгийг ойлгож мэдсэн байдаг. Нэг соёлтой хүмүүс хүртэл бие биеэсээ өөр. Бид алс холын хүнтэй уулзах эсвэл дээр үеийн хүмүүсийн тухай уншихад сэтгэл зүй, мэдрэмж болон сүнслэг талаараа ч асар их ялгаатайг нь анзаардаг. Хүн бүр туулсан амьдрал, давуу тал, айдас, ур чадвар болон сүнслэг өсөлт гээд олон талаараа өөр. Магадгүй тэр бүх ялгаанууд маш урт жагсаалт болох байх. Тиймээс бид Шинэ Гэрээний теологийг судалж байхдаа өнөө үе болон Шинэ Гэрээний үеийн хүмүүсийн адил төстэй, мөн ялгаатай талуудыг анхаарах нь зүйн хэрэг.”


Бүгдээрээ өмнөх хоёр нөхцөлийн тухай ярилцсаны адил хувь хүнтэй холбоотой нөхцөлийг авч үзэцгээе. Эхлээд орчин үе болон Шинэ Гэрээний цаг үеийн хооронд хувь хүнтэй холбоотой үргэлжлэх зарчмууд нь юу байдаг? Дараа нь үл үргэлжлэх зарчмууд нь юу вэ? гэдэгт хариулна. Тэгэхээр одоо үргэлжлэх зарчмуудын тухай ярилцъя.

Үргэлжлэх зарчмууд

Библийн өнцгөөс бид Шинэ Гэрээнээс сурч, хэрэгжүүлэхдээ итгэлтэй байж болохуйц хүмүүсийн дундах ижил төстэй зүйлс хангалттай байгааг харж болно. Үнэндээ Бичвэр бидэнд Шинэ Гэрээний болон орчин цагийн хүмүүс бүгд л яг адил төрлийн хүмүүс гэдгийг хэлж өгдөг. Шинэ Гэрээг бичсэн хүмүүс, уншигчид болон түүнд гарч буй хүн бүр яг л бидний адил Бурханы төрхөөр бүтээгдсэн хүмүүс юм. Тэд бидэнтэй адил бодит зүйлст дуртай, учир шалтгааныг эрж хайдаг байсан. Тэд баярлаж бас гунигладаг байсан. Тэд бидний л адил Христийн аврал хэрэгтэй, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, унасан хүмүүс байв. Тэд унасан энэ дэлхийд гэм нүгэлтэйгээ тэмцэлдэж, өвчин зовлон, хатуу хүтүүг туулдаг. Шинэ Гэрээний үед Христэд итгэсэн хүмүүс өнөөдрийн итгэгч нарын л адил Бурханы уучлалыг болон Ариун Сүнсний ерөөлийг амьдралдаа мэдэрч байсан. Эдгээр хувь хүний үргэлжлэх зарчмуудын ачаар бид Шинэ Гэрээний үеийн хүмүүсийг амархан ойлгож амьдралтайгаа холбож чаддаг.

Жишээ нь Ром 9:2-4-р эшлэлд Паул Иудей хамтрагч нартаа хандан сэтгэлийн гүний мэдрэмжээ ийнхүү илэрхийлсэн байдаг:

Ариун Сүнсээр надад гэрчилж байгаачлан зүрхэнд минь маш их уйтгар гуниг, байнгын зовуурь байна. Мах биеэрээ миний хамаатан болох



All human beings in New Testament times and today are the same kinds of people.

ахан дүүсийнхээ төлөө би Христээс салгагдаж, өөрөө хараал болох минь гэж хүсэж байлаа (Ром 9:2-4).

Энэ эшлэл Паулын хувийн сэтгэл хөдлөл мэдрэмжийг харуулж байна. Хүний зан чанар Паулын амьдарч байсан үеэс хойш нэг их өөрчлөгдөөгүй тул бид түүний мэдрэмжийг ойлгохгүй өнгөрөхийн аргагүй биз ээ. Энэ мэт хувь хүний үргэлжлэх зарчмууд нь бидэнд Шинэ Гэрээг бичсэн хүмүүс, уншигчдын санаа зорилгыг болон гарч буй бүх дүрийн туулж буй бүхнийг мэдэрч ойлгоход дөхөм болгож өгдөг. Тиймээс тэдний туршлагыг бид өнөөдөр амьдралдаа хэрэгжүүлж болно гэсэн үг.

Шинэ Гэрээний хувь хүнтэй холбоотой олон үргэлжлэх зарчмууд байдаг хэдий ч яг үүнтэй зэрэгцэн мөн түүнээс дутахгүй тооны үл үргэлжлэх зарчмууд бий. Үүнээс болж бид Шинэ Гэрээний теологийг ойлгож амьдралдаа хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг.

Үр үргэлжлэх зарчмууд

Шинэ Гэрээнд олонтоо дурдагдсан байдаг зарим нэг онцгой төрлийн хүмүүс өнөөгийн хүмүүсээс их ялгаатай байдаг тул бүрэн ойлгож амьдралтайгаа холбоход бэрхшээл тулгардаг. Хувь хүний, сэтгэл мэдрэмжийн чиг хандлага, тэр бүү хэл нас, хүйстэй холбоотой асуудлууд бидэнд бэрхшээл үүсгэх бөгөөд бид чухамдаа анхааралтай судалж байж л эдгээр бэрхшээлийг давна.

Бурхан ямар нөхцөл байдалд байгаа, ямар ч орчинд төрж өссөн бай хамаагүй хүмүүсийг анхаарч хайрладаг. Библийн янз бүрийн хэсэгт үнэндээ хэчнээн олон төрлийн амьдрал болон нийгэм соёлын нөхцөл байдлууд гардаг билээ дээ. Бурхан хүмүүст байгаа нөхцөл байдал бүрд нь хэрхэн тохируулан үгээ хэлж байсныг бид ойлгох юм бол тэдгээр жишээнээс суралцаж мөн өөрсдийн өөр өөр нөхцөл байдал бүхий амьдралдаа хэрэгжүүлэх болно. Бурхан бодит арга замаар, тодорхой нөхцөлд ажилласан байдаг тул биднийг ч мөн бодит арга замаар, тухайн нөхцөлдөө хэрэгжүүлээсэй хэмээн хүсэж байдаг. Гэхдээ бид бичээс дэх зөв зарчмыг нь эхлээд сайтар ойлгох хэрэгтэй. Тэгж байж л амьдралдаа зохих ёсоор нь хэрэгжүүлж чадна.

— Др. Крэйг С. Кийнэр
Асбури Теологийн Их Сургууль

Жишээ нь: Ефес 6:5, 9-р эшлэлд Паул хоёр төрлийн хүмүүсийг онцгойлон дурдсан байдаг:

Боолууд аа, Христэд ханддаг шигээ та нар махбодын дагуух эздэдээ ч эмээхүй ба чичрэлээр, чин сэтгэлээсээ дуулгавартай бай... Эзэд ээ, үүний адил боолууддаа ханд. (Ефес 6:5, 9).

Ихэнхдээ бид энэ эшлэлийг уншаад Паул Ефес хотын чуулганд хамрагддаг байсан боолууд болон эздэд хандан хэлжээ гэдэг өнгөцхөн талаас нь л ойлгодог. Гэвч Христийн доторх тэдгээр ахан дүүс маань яг ямар амьдрал туулж байсан тухай ойлголт маань тун хязгаарлагдмал байдаг. Учир нь бидэнд боол болон эзний харилцааны тухай бодит мэдлэг ойлголт байдаггүй.

Эдгээр хүмүүс нь өнөө цагийн хүмүүсээс маш их ялгаатай хүмүүс байсан. Тиймээс бид тэдгээр хүмүүс анхны зууны үед Ефес гэх мэт хотуудад чухам ямар амьдрал туулж, юутай нүүр тулдаг байсныг нь ойлгохын тулд сайтар судлах хэрэгтэй. Өнөөгийн амьдралтай ижил төстэй талуудыг олж харан, Паулын энэ эшлэлд өгүүлж буй теологийн үзлийг ойлгохын тулд бид тийнхүү гүнзгий судлахаас өөр аргагүй.

Шинэ Гэрээг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх ёстойгоо ойлгохыг оролдох бүрдээ бидний байнга тулгардаг нэг түлхүүр үг бол “хам сэдэв” юм. Бичвэрийг сайтар ойлгож өө сэвгүй хэрэгжүүлэх гэж хичээх тусам Шинэ Гэрээний үед ч ингэх нь хэцүү байсныг ойлгох болно. Паул нэг удаа “Тиймээ, Тимот оо, чи сайн мэдээний төлөө хөвч хөндүүлэх ёстой” гэж хэлсэн хэр нь өөр нэг тохиолдолд өөр нэг хамтрагчдаа хандан “Үгүй ээ, чи сайн мэдээний төлөө хөвч хөндүүлэхээс татгалзах ёстой” гэж хэлсэн байдаг. Үүнээс харвал нэг ижил төрлийн үйлдэл нөхцөл байдлаас шалтгаалан буруу эсвэл зөв байх боломжтой. Нэг тохиолдолд нь “Тимот оо, чи хөвч хөндүүлбэл Иудей хүмүүст сайн мэдээ тарааж чадна” гэж хэлсэн. Энэ нь Сайнмэдээний төлөө байсан. Харин нөгөө тохиолдолд нь “Чамайг хөвч хөндүүлэхийг шаардаж байгаа хүмүүс авралд хүрэхийн төлөө хөвч хөндүүлэх ёстой гэж боддог тул сайн мэдээний төлөө чи яасан ч хөвч хөндүүлж болохгүй” хэмээн Титэд хандаж хэлсэн харагддаг. Тиймээс бид одоогийнхоо соёлын нөхцөл байдал болон үүнд Библийн зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхийг сайтар ойлгох хэрэгтэй. Бид соёлын нөхцөлийг хэдий чинээ сайн ойлгоно, төдий чинээ Бичвэрийг сайтар ойлгоно гэсэн үг.

— Др. Дан Лагих
Нордланд. Тархсан Чуулган

Шинэ Гэрээний үед амьдарч байсан эрүүл, өвчтэй, хүчтэй, сул дорой, баян, ядуу, хөгшин, залуу, эцэг эх, ах эгч дүүс гээд хүн бүр Шинэ Гэрээний теологийг өөр өөрсдөдөө тохирсон арга замаар хүлээн авч байсан. Энэ мэт олон ижил төстэй хувь хүнтэй холбоотой хүчин зүйлс бидэнд Шинэ Гэрээний теологийг өнөө цагт хэрэгжүүлэхэд янз бүрээр нөлөөлсөөр байх болно. Эдгээр хувь хүнтэй холбоотой нөхцөлүүд бид бүгдийг Шинэ Гэрээгээ нухацтайгаар хичээнгүйлэн судлахыг шаардаж байна.

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Христийн дагалдагч нар яагаад Шинэ Гэрээний теологийг судлах ёстой гэдгийг олж мэдлээ. Бид Шинэ Гэрээний онгод ба эрх мэдлийн тухай үзэж, Шинэ Гэрээ бол Бурханы амьсгалаар бичигдсэн тул бид шимтэн судлахад өөрсдийгөө зориулах ёстой тухай ярилцсан. Мөн бид Шинэ Гэрээний үеэс өнөөгийн бидний үе хүртэлх цаг үеийн, соёлын болон хувь хүнтэй үргэлжлэх болон үл үргэлжлэх зарчмуудын тухай үзэхдээ Шинэ Гэрээний теологийг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд эдгээр нөхцөлүүдийг яагаад судлах хэрэгтэй тухай ярилцсан.

Шинэ Гэрээ бол зүгээр нэг гүйлгэж уншаад өнгөрөх ном бишээ. Энэ бол сүм чуулгандаа хандаж хэлсэн Бурханы Үг учраас бид сайтар судлан ойлгохын тулд шаардлагатай бүхнийг хийхэд бэлэн байх хэрэгтэй. Бид дараагийн хичээлээрээ энэ зорилгыг биелүүлэхэд шаардлагатай чухал арга замуудын тухай үзэх болно. Ингэхдээ бид Библийг энэ талаас нь анхааралтай судлахын олон ач тусыг олж харах болно. Ингээд бүгдээрээ удалгүй Шинэ Гэрээний теологийг судлахад яагаад өөрсдийгөө зориулах ёстой тухай үзэцгээе.

ХАМТРАГЧИД

Др. Симон Вибэрт (хөтлөгч) бол Оксфордын Их сургуулийн Вайклифе танхимын дэд захирал бөгөөд мөн Номлохуйн Сургуулийн захирлаар ажилладаг. Др. Вибэрт нь Теологийн Магистрын зэргээ Гласгоугийн Их сургуулиас, Үйлчлэлийн Доктор зэргээ Реформэд Теологийн сургуулиас, Дээд боловсролын Суралцахуй ба Заахуйн ухааны Бакалаврын зэргээ Оксфордын Их сургуулиас тус тус авсан. Мөн тэрээр Латимар Трастын захирал, Английн Эвангелийн Зөвлөлийн чуулганы гишүүн бөгөөд Үг ба Сүнсний Нөхөрлөлийн гүйцэтгэх захиралаар тус тус үйлчилдэг. Др. Вибэрт мөн Гэгээн Лукийн Вилбэлдон Парк чуулганы номлогчоор 8 жил үйлчилсэн. Тэрээр олон тооны теологийн ном, өгүүлэл бичсэн бөгөөд үүнд *Excellence in Preaching: Learning from the Best* (IVP, 2011); *Stress: The Path to Peace* (Inter-Varsity Press, 2014); болон *Lives Jesus Changed* (Christian Focus Publications, 2010) зэрэг номууд багтдаг.

Др. Марк А. Женнингс бол Гордон Конвэл Теологийн Шинэ Гэрээний багш.

Др. Эдвард М. Киазириан бол Гордон Конвэл Теологийн Сургуулийн Грек Хэлний хөтөлбөрийн захирал ба Грек хэлний туслах Профессор.

Др. Крейг С. Кийнэр бол Ф.М ба Ада Томпсон Асбури Теологийн Сургуулийн Библи судлалын захирал.

Др. Дан Лагих бол Флорида мужийн Орланда дахь Нортланд чуулганы пастор.

Др. Жэйсон Оакес бол Теологийн Талбот Сургуулийн Библи ба Теологийн судлалын туслах Профессор.

Др. Грэг Пэрри бол Ковенэнт Теологийн Сургуулийн Хотын Үйлчлэлийн Санаачилгын Захирал ба Шинэ Гэрээний туслах Профессор.

Рэв. Рик Роудхивэр бол Калифорний Лагуна Хиллс дэх Христийн Коммунити Чуулганы Ахлах Пастор.

Др. Экхард Ж. Шнабел бол Гордон-Конвел Теологийн Сургуулийн Шинэ Гэрээ Судлалын Мари Ф. Рокфеллар Олонд танигдсан Профессор.

Др. Глен Г.Скоржиэ Сан Диего дахь Бетэл Сургуулийн Теологийн Профессор.

Др. Марк Л. Страусс бол Сан Диего дахь Бетэл Сургуулийн Шинэ Гэрээний Профессор.

Др. Стефен Ж. Вэллум бол Өмнөд Баптист Теологийн Сургуулийн Христитгэлийн Теологийн Профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

элч– Есүсийн дагалдагч, амилсан Эзэнийг нүдээр гэрчлэгч, Их Эзэний Өөрөө үйлчлэлд сонгож илгээсэн, Шинэ Гэрээн дэх онцгой үүрэг бүхий зарлага, төлөөлөгч, элчин сайдыг хэлнэ

эрх мэдэл – Нөлөөлөх, тушаах болон зан хандлага, үйл хэргийн жишгийг тогтоох хүч чадал

соёлын үргэлжлэх зарчмууд– Газар зүй, цаг хугацааны явцад ч нэг соёл нөгөө соёлтойгоо ижил төстэй байх явдал

соёлын үл үргэлжлэх зарчмууд– Хэл, утга зохиолын ёс заншил болон улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны хувьд нэг соёл нөгөө соёлоосоо ялгаатай байх явдал

соёл– Хамтын ойлголт, зан дадал болон мэдрэмжээс бий болдог хүний нийгмийн хэв маяг

дагалдагч– Агуу багш эсвэл удирдагчийн суралцагч, шавь, дагалдагч

цаг үе – Түүхийн нэгэн онцлог хугацаа буюу теологийн хувьд энэ нь бусад цаг үеэс ялгагдах тэнгэрлэг илчлэлээр тогтоогдсон цаг хугацаа

цаг үеийн үргэлжлэх зарчмууд– Түүхийн нэг цаг үе ба нөгөө цаг үе хоорондын холбоос

цаг үеийн үл үргэлжлэх зарчмууд– Түүхийн нэг цаг үе ба нөгөө цаг үе хоорондын ялгаатай зүйлс

Грек хэл– Шинэ Гэрээний эх хэл. Мөн Христээс өмнөх 2 ба 3-р зуунд Хуучин Гэрээг Еврей хэлнээс хөрвүүлж байсан хэл

хувиршгүй –Энэ нь "өөрчлөгдөшгүй" буюу Бурханы өөрчлөгдөшгүй, төгс

төгөлдөр мөн чанарыг илэрхийлэхдээ ашигладаг үг

Онгод – Бурханы илчлэлийг Бичээс болгон бичүүлэхийн тулд Ариун Сүнс хүмүүнийг хөтлөн удирдаж, эдгээрийг алдаа мадаггүй байлгахаар чиглүүлж буй арга замыг хэлнэ

Иудас – Есүсийн арван хоёр дагалдагчийн нэг. Гучин мөнгөн зоосны төлөө Есүсээс урваж, ахлах тахилч нартай хуйвалдсан нэгэн

Механик онгод – Ариун Сүнс хүмүүнд үгээ хэлж Библийг бичүүлсэн гэдэг онгодын нэг хэлбэр бөгөөд хүмүүс Түүний хэлснийг үг бүрчлэн бичиж тэмдэглэсэн гэдэг

Органик онгод– Ариун Сүнс хувь хүний зан чанар, үзэл бодол болон амьдралын туршлагыг ашиглан эрх мэдэлтэйгээр бас алдаа мадаггүйгээр хөтлөн бичүүлсэн гэсэн үзэл

Эш үзүүлэгч – Бурханы үгийг тунхаглаж, хэрэгжүүлдэг, Бурханы сонгосон нэгэн. Онцгойлон гэм нүглийн эсрэг шүүлтийг тунхаглаж, ерөөлд хөтлөх үнэнч итгэмжит үйлчлэлийг урамшуулдаг нэгэн

Романтик онгод – Ариун Сүнс Библийг бичсэн хүмүүсийг онгод оруулсан хэдий ч бичих зүйлд нь захирах байдлаар оролцоогүй гэсэн үзэл

Самаричууд– хойд хаант улсад амьдарч байсан Израильчуудтай гэрлэсэн харь шашинтай өвөг эцэгтэй самари хүмүүс. Тэд Иудейн шашны холин хутгах үзэлтэй байсан бөгөөд Иудейчүүд тэднийг цэвэр биш үндэстэн гэж үздэг байв

теологи– Бурхантай шууд холбоотой эсвэл аливааг Бурхантай холбон тайлбарласан үзэл баримтлал ойлголтууд

